

*Мал аж ахуйн тогтвортой
үйлдвэрлэл эрхэлж, байгалийн
тэнцвэрт байдлыг хадгалах*



ТОГТВОРТОЙ НООЛУУРЫН БАТАЛГАА

Бид ноолуураа тогтвортой ноолуурын 25 шалгуур болон түүхий эд ангиллын батлагдсан схемийн дагуу бэлтгэдэг бөгөөд хоршооны гишүүд нь Тогтвортой ноолуур гэрчилгээтэй. Ноолуурын баталгааг шалгах гадны болон дотоод хяналттай. Дотоод хяналтыг хоршооны Бүлэг хариуцсан малчин нь шалгууруудын дагуухийж, онооны үнэлгээ өгдөг бол Гэрчилгээг аймгийн болон үндэсний хэмжээний Гэрчилгээжүүлэлтийн хороо баталгаажуулж, олгодог.

“ТОГТВОРТОЙ НООЛУУР” ХОЛБОО

“Тогтвортой ноолуур” холбоо нь AVSF Монгол буюу Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид байгууллагын дэмжлэгтэйгээр тогтвортой ноолуур бэлтгэгч хоршоодын санаачилгаар байгуулагдсан бөгөөд ашгийн бус, гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага юм. Өнөөгийн байдлаар “Тогтвортой ноолуур” Холбоо нь Баянхонгор аймгийн таван хоршооны 350 орчим өрхийн 1600 гаруй малчинтай.



ХОЛБОО БАРИХ:

Хоршооны дарга
Г. Энхтайван +976 88870553

Хоршооны Гүйцэтгэх захирал
Б. Мөнхзул +976 88989990



ӨГӨӨЖ БАЯН ӨЛЗИЙТ ГОЛ ХОРШОО

БӨМБӨГӨР СУМ,
БАЯНХОНГОР АЙМАГ





ХОРШООНЫ ТАНИЛЦУУЛГА

“Өгөөж баян өлзийт гол” Хоршоо нь анх 2016 онд 48 гишүүнтэй байгуулагдаж, өдгөө бэлчээр ашиглагчдын гурван хэсгийг хамруулан 61 гишүүнтэй болж өргөжөөд байна. Хоршоо нь Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны гишүүн бөгөөд Хоршооны дарга, нягтлан бодогч, техникч малчин, тэргүүлэгч, хяналтын зөвлөлийн гишүүдтэй. Мөн манай хоршоо “Тогтвортой ноолуур” Холбооны гишүүн бөгөөд Бөмбөгөрийн улаан омгийн ямааны ноолуур бэлтгэгдгээрээ онцлогтой.

ХОРШООНЫ ЗОРИЛГО

Манай хоршооны зорилго мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхэлж, байгалийн тэнцвэрт байдал хадгалж, гишүүдийнхээ амьжиргааг дэмжихийн зэрэгцээ бэлчээрийн зөв зохистой менежментийг хэрэгжүүлэхэд оршино.



ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Өгөөж баян Өлзийт гол” хоршоо нь малынхаа түүхий эд буюу ноолуурыг байгальд ээлтэй, хоршооны гишүүдэд тэгш хүртээмжтэй, эдийн засгийн шударга хуваарилалттай аргаар бэлтгэн, “Тогтвортой ноолуур” холбоогоор дамжуулан нэмүү өртгөөр борлуулдаг юм.

Манай хоршоо цөм сүргийн ямаатай бөгөөд цөм сүргээсээ сайн чанарын хээлтүүлэгчийг гишүүддээ нийлүүлж, өвс тэжээлийг үйлдвэрээс татаж хөнгөлөлттэй үнээр гишүүддээ олгож, сумын мал эмнэлгийн газартай хамтарч гишүүдийнхээ малыг тарилга туулгад тогтмол хамруулдаг. Түүнчлэн бид тэргүүлэгч, Хяналтын зөвлөлийн гишүүдийнхээ нийгмийн даатгалын шимтгэлийг төлж, гишүүдийнхээ эрүүл мэндэд анхаарч эмчийн үзлэгт хамруулж байна.

Хоршооны борлуулалтын ашгийг тогтвортой хөгжлийн, нийгмийн, эрсдэлийн болон малын тэжээлийн сангуудад тус тус хуваарилж, Тогтвортой хөгжлийн сангийн хөрөнгийг бэлчээр хамгаалах, фотомониторинг хийх, өвөлжөө хаваржааны хашаа хороог сэргээн засах, шинээр барих, худаг ус сэргээн засварлах зэрэг ажлуудад зарцуулж, хамтран ажилладаг. Хоршооны гишүүд нь бүгд малын эрүүл мэнд, бэлчээрийн зохистой менежментийн сургалтуудад хамрагдаж, нийгэм соёлын харилцаанд орж, хамтран ажиллах дадалтай болсон.

ЦААШДЫН ЗОРИЛТ

Бид 2021 оноос хоршооны цар хүрээгээ тэлж, гишүүнчлэлээнэмэгдүүлэхээртөлөвлөжбайгаагаас гадна ноолуурынхаа хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлд түлхүү анхааран ажиллана. Мөн захиалагчдынхаа итгэлийг дааж, гэрчилгээжсэн тогтвортой ноолуурыг тогтмол баталгаатай нийлүүлж, аймаг, нутгийнхаа нэр болон улаан ямааны ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлж, удмын санг нь хадгалж, дотоод, гадаадын хэрэглэгчдэд таниулахад хувь нэмрээ оруулах зорилго тавьж байна.

